

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: УАГ-НАГ-2020/01/-НА

БУЛГАН ХОТ 2019 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг:
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Ахлах аудитор Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг:
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг:
Аудитор З.Ганбаатар
Утас: 703427116 Цахим хаяг:
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг:
Аудитор Г.Цэрэнлхам
Утас: 70342716 Цахим хаяг

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Аудитын тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт..... 4
Дарга, Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....5-6
Аудитын менежер Ж.Энхцоодол	Бүлэг 1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх? 6-9
Ахлах аудитор Г.Намчинсүрэн	1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд нь нийт 4787 мэдээллийг мэдээллээс 4608 мэдээллийг байршуулан шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг тогтмол мэдээлэх үүргийн хэрэгжилт 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна.....8
Аудитор 3.Ганбаатар	1.2. Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгаагүйгээс байгууллагууд мэдээллийг самбартаа дутуу байршуулж байна.....8-9
Судалгаа бэлтгэсэн:	1.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамтай холбоотой мэдээлэл бөгөөд орон нутагт хамааралгүй байна.....9
Ахлах аудитор Г.Намчинсүрэн	
Аудитор П.Мөнхтуяа	
Г.Цэрэнлхам	
П.Содном	
Б.Энхтөр	
3.Ганбаатар	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7034-2495 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5 дахь заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх?8-10
ХАЯГ:	2.1. “Булган АЗЗА” ТӨХК нь тухайн жилд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын талаарх мэдээллийг бүрэн мэдээлсэн ч, шилэн дансны нэгдсэн цэсэд Засгийн газрын орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, шийдвэр, худалдан авах ажиллагааны тайлан зэргийг байршуулаагүй байна.....9-10
Нутгийн удирдлагын ордон 403 тоот	2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж,
Булган аймаг	
Булган сум	

	байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдалт, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлэхгүй байна.....9-10
	2.3 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдалт хангалттай байгаа боловч, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.....10-11
	Бүлэг 3 Хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан эсэх.....12-13
	3.1 Аймаг, сумдын ИТХ шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг, дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлж ажилласан боловч Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалт бүрэн хэрэгжихгүй байна.....13
	3.2 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувь, зөвлөмжийг 66.6 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.....14
	Дүгнэлт13
	Зөвлөмж 15
	Тэргүүлэх аудиторын тушаал..... 16
	Холбогдох байгууллагын санал..... 17
	Судалгааны маягт №1-5.....18-33
	Зөрчлийн нэгтгэлийн хүснэгт.....34-40

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын их хурал
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААН	Аж ахуй нэгж
АЗЗА	Авто зам, засвар, арчлалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийлээ.

Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх.
- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5 дахь хэсэгт заасан төрийн байгууллага, хуулийн этгээдийг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын мэдээнд үндэслэн эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгалаа.

Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100,400, 4000 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага, зохион байгуулах, иргэд, хэрэгдэгчдээс судалгаа авах зэрэг аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 04 дүгээр сарын 16-ны өдрөөс тус тус эхлүүлэн гүйцэтгэж, аудитын нэгдсэн тайланг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлээ.

Аудитыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн ахлан, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор З.Ганбаатар, Э.Энхтөр, Г.Цэрэнлхам нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Булган аймгийн хэмжээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 223 байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс Улсын төсвийн 34, орон нутгийн 189 байгууллагаас 18 улсын төсвийн байгууллагыг маягтын дагуу нэгтгэж орон нутгийн 78 байгууллагыг түүвэрт хамруулан тайланд тусгалаа.

Бүлэг 1

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?

1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд нь нийт 4787 мэдээллийг мэдээллээс 4608 мэдээллийг байршуулан шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг тогтмол мэдээлэх үүргийн хэрэгжилт 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаандаа мэдээллийг тогтмол мэдээлэх үүргийн хэрэгжилт 93.4 хувтай байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн 78 байгууллагыг түүвэрт хамруулж аудитыг гүйцэтгэлээ.

Тайлант онд дээрх түүвэрт хамруулсан байгууллагууд 6.1.1-6.1.6 дахь заалтад хамрагдах 852 мэдээллийг мэдээлэхээс 796 буюу 93.4 хувийг хугацаанд нь мэдээлж, 12 хувийг хугацаа хоцроон мэдээлж 6.6 хувийг огт мэдээлээгүй байна.

ОНӨХЭ-ийн шилэн дансны мэдээллээ байршуулсан байдал	6.1.1 Тухайн жилийн төсөв	6.1.1 ХАА-ны төлөвлөгөө	6.1.1 ОНХС-ийн төлөвлөлт	6.1.2 Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	6.1.3 Дараа жилийн төсвийн төсөл	6.1.4 Жилийн эцсийн тайлан	6.1.5 ТӨЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	6.1.6 Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны
Мэдээлсэн	45	38	7	72	60	57	33	283
Мэдээлээгүй	3	0	0	4	2	16	19	12
Хугацаа хоцроож мэдээлсэн	29	38	0	1	15	3	3	13
Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй	0	1	71	1	1	2	22	1
Тухайн мэдээллийг мэдээлсэн хувь	96	100	100	95	97	79	75	96

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2- дахь заасан байгууллагууд тогтмол хугацаанд мэдээллийг ил тод цахим хуудсанд мэдээлсэн нь 93.4 хувтай байгаа нь өмнөх оноос 11.3 хувиар өссөн дүнтэй байна.

1.1.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан 3623 мэдээллээс 3500 мэдээллийг байршуулан 96.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан 9 төрлийн мэдээллийг 7 хоногийн дотор нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит 78 хуулийн этгээдэд 6.4.1, 6.4.2, 6.4.6, 6.4.7 дахь нийт мэдээлэх 312 удаагийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлэхээс 223 удаагийн буюу 72 хувийг цахим хуудсаар мэдээлж үлдсэн 28 хувь нь хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй гэж мэдээлсэн байна.

Д/д	Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээлэл	Байгууллагын тоо	Мэдээлсэн	Мэдээлээгүй	Хугацаа хоцроож мэдээлсэн	Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй
1	6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	78	76	0	1	1
2	6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	78	23	0	0	55
3	6.4.3. Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	139	130	9	0	0
4	6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	319	314	5	0	0
5	6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	450	428	22	0	0
6	6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	461	441	20	0	0
7	6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	78	47	0	0	31
8	6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	78	77	0	0	1
9	6.4.8. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	2254	2187	67	0	0

Дээрх судалгаанаас үзэхэд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь худалдан авалтын мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийн нийт 3623 мэдээллээс 3500 мэдээллийг хугацаанд нь, 123 мэдээлэл буюу 3.4 хувийг мэдээлээгүй байна.

1.2. Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгаагүйгээс байгууллагууд шилэн дансны мэдээллийг байгууллагын самбартаа дутуу байршуулж байна.

1.2.1. Төсвийн шууд захирагчдын 21 байгууллагын мэдээллийн самбарыг үзэхэд 95.2 хувь нь мэдээллийн самбартай байна.

Аймгийн төвийн төсвийн шууд захирагчдын 21 байгууллагын мэдээллийн самбарыг аудитын явцад тухайн байгууллага дээр очиж үзэхэд шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн стандартыг тодорхой тусгаагүйгээс байгууллага бүр мэдээллийн самбарт мэдээлэх мэдээллийн төрөл харилцан адилгүй байна.



Мэдээлж байгаа мэдээлэл нь голдуу сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг байгаа бөгөөд худалдан авалтын жилийн төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, тендерийн талаарх мэдээлэл, хөрөнгө мөнгө зарцуулах талаарх тушаал шийдвэр зэрэг мэдээлэл харьцангуй бага байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 5.7 дахь заалт бүрэн хэрэгжихгүй байна.

Аудитын явцад Булган сумын ойн анги нь шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

1.2.2. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын мэдээллийн самбарыг үзэхэд олон нийтэд мэдээлсэн мэдээл нь 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан тамга тэмдэгтэй хуулбарыг байршуулан ажиллаж байна.

Аудитын явцад 21 байгууллагын мэдээллийн самбарыг шалгахад 20 байгууллагын мэдээллийн самбарт тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсэг, тамаг тэмдгээр баталгаажсан, олон нийтэд ил, ойлгомжтой байдлаар тайлагнаж байршуулсан байна. Энэ нь аймгийн төвийн түүвэрт хамрагдсан байгууллагаар дүгнэхэд хуулийн 7 дугаар зүйлд заасан эрх бүхий албан тушаалтнууд мэдээллийг хуульд зааснаар хэрэгжүүлж ажилласан байна.

1.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамтай холбоотой мэдээлэл бөгөөд орон нутагт хамаагүй болно.

Бүлэг 2

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5 дахь заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх?

2.1. “Булган АЗЗА” ТӨХК нь тухайн жилд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын талаарх мэдээллийг бүрэн мэдээлсэн ч, Засгийн газрын орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, шийдвэр, худалдан авах ажиллагааны тайланг зэргийг байршуулаагүй байна.

2.1.1. “Булган АЗЗА” ТӨХК нь тухайн жилд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын талаарх мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн 6.8 дахь заалтын дагуу хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын талаарх мэдээллийг 3.1.3 дахь заасан байгууллагууд 7 хоногийн дотор мэдээлэх үүрэгтэй.

Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшигч “Булган АЗЗА” ТӨХК нь 6 хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тус тус хуулийн хугацаанд мэдээлж ажилласан байна.

“Булган АЗЗА” ТӨХК нь тендер, худалдан авалтын талаарх 1 мэдээллийг мэдээлэхээс 1 мэдээлж ажилласан нь өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилган ажиллажээ.

Харин хуулийн 6.8.2 дахь худалдан авах ажиллагааны тайланг тухайн жилд мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэн ажиллаа.

2.1.2. Булган АЗЗА ТӨХК нь шилэн дансны нэгдсэн цэсэд бусад шийдвэр үйл ажиллагааны талаарх мэдээллийг огт байршуулаагүй байна.

Шилэн дансны хуулийн 3.1.3 дахь хамрагдах компани нь тус хуулийн 6.8 дахь мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлэх үүргийг хуулиар хүлээсэн байдаг.

Булган АЗЗА ТӨХК нь Засгийн газрын орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, шийдвэрийн талаарх 25 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Мөн шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт огт мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.7, 6.8.1 дэхь заалттай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлж ажиллаа.

2.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдалт, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлэхгүй байна.

2.2.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансанд хамрагдалт хангалтгүй байна.

Булган аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 86 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг 69 аж ахуй нэгж гэрээгээр гүйцэтгэсэн байна.

Дээрх нийт 69 аж ахуй нэгжүүдээс 15 аж ахуй нэгж буюу 21.7 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд гүйцэтгэж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат талаарх мэдээллийг шилэн дансанд мэдээлэх эрх нээгдсэн байна. Үүнээс дүгнэхэд Шилэн дансны тухай

хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад хамаарах аж ахуй нэгж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдалт маш хангалтгүй байна.

2.2.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат талаарх мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Мэдээллээ байршуулах эрх нээгдсэн дээрх 15 аж ахуй нэгжээс 2 аж ахуй нэгж 3 хөрөнгө оруулалтын 392.4 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээг байршуулж 86.6 хувь нь гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээний төсөв өртөг, хэрэгжилтийн явц, үе шат талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдал хангалтгүй байгаа тул санхүүжилт олгогч байгууллагуудын зүгээс хяналт тавих, хөрөнгө оруулалт, ажил гүйцэтгэх гэрээнд хуулиар хүлээсэн дээрх чиг үүргийг гэрээний тусгай нөхцөлд оруулж хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна.

Мөн өмнөх онд хийгдсэн аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгжүүдийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчил илэрч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах арга зам, хариуцах байгууллага, хүлээлгэх хариуцлагын талаарх тогтолцоог хууль, журамд тодорхой тусгуулах арга хэмжээ авахыг зөвлөмж болгосон ч бүрэн хэрэгжүүлээгүйгээс Шилэн дансны тухай хуулийн 6.9 дахь заалт бүрэн хэрэгждэггүй, хяналт хангалтгүй байна.

2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдалт хангалттай байгаа боловч, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.

2.3.1. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид зарлага, санхүүжилтийн мэдээллийг шилэн дансанд мэдээлэх эрх нээгдсэн байна.

Булган аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад хамаарах хувийн хэвшлийн 18 мал эмнэлэг төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэснээс 17 аж ахуй нэгж буюу 95.1 хувь нь зарлага, санхүүжилтийн мэдээллийг шилэн дансанд мэдээлэх эрх нээгдсэн байна.

2.3.2. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид зарлага, санхүүжилтийн мэдээллийг шилэн дансанд 54.9 хувь нь огт мэдээлээгүй байна.

Мэдээллээ байршуулах эрх нээгдсэн 17 аж ахуй нэгж, байгууллагаас зарлага санхүүжилтийн мэдээллийг 9 аж ахуй нэгж буюу 54.9 хувь нь огт мэдээлээгүй, 8 аж ахуй нэгж буюу 47 хувь нь зөвхөн 1 дүгээр улирлын ажил, үйлчилгээний

гүйцэтгэлийн санхүүжилтийг мэдээллийг мэдээлээд 2, 3, 4 дүгээр улирлын санхүүжилтийн мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь аж ахуй нэгж, байгууллагуудын шилэн дансанд байршуулсан мэдээллийг нягтлан үзэхэд холбогдох мэдээллийг байршуулснаар мэдээлсэн боловч мэдээллийн агуулгыг мэдээлээгүй, санхүүжилт авсан боловч холбогдох мэдээлэл байхгүй зэргээр мэдээлэл байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4.1, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5.1 дэх заалтуудтай бүрэн нийцэхгүй байна.

Бүлэг 3

Хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан эсэх ?

3.1. Аймаг сумдын ИТХ шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг, дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэн ажилласан боловч Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалт бүрэн хэрэгжихгүй байна.

3.1.1. Аймаг сумдын ИТХ, шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Шилэн дансны хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн нийтийн Хурал хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-аас хяналтын чиг үүргийнхээ дагуу хуулийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.Үүнд:

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр хуралдаанаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хэлэлцэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 24 дүгээр тогтоол баталсан.
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тухай аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд мэдээллээ хоцроосон ажилтнуудад хариуцлага тооцох албан бичиг явуулсан.
- Сангийн яам, аймгийн Засаг дарга, Санхүү хяналт, аудитын албатай хамтран төсвийн шууд захирагч нар болон нягтлан бодогч нарт зориулсан “Шилэн дансны хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна.

Сумдын ИТХ аймгийн ИТХ-аас үүрэг болгосны дагуу сумдын төсвийн шууд захирагчдын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хөндлөнгийн

хяналтыг хэрэгжүүлж хяналт шалгалт хийсэн ажлын тайланг аймгийн ИТХ-д ирүүлж хэвшсэн байна.

3.1.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын алба харьяа төсвийн байгууллага “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.25-т заасны дагуу харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд улирал тутам хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Хэдийгээр шилэн дансны хуулийн хэрэгжилтийг улирал бүр хяналт тавин ажиллаж байгаа боловч Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалт бүрэн хэрэгжихгүй хангалтгүй байна. Иймд Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан хуулийн этгээдийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамруулах, холбогдох мэдээллээ бүрэн бүрэн байршуулсан эсэхэд аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Санхүүгийн хяналт, аудитын алба уялдаа холбоотой ажиллах, хяналт тавих, хэрэгжилтийг хангуулахад анхаарах шаардлагатай байна.

3.2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувь, зөвлөмжийг 66.6 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

3.2.1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх аудитаар нийт 76 төсвийн шууд захирагчид шилэн дансны аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилган цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг нөхөн мэдээлэх арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.2.2.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

Өмнөх шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах арга зам, хариуцах байгууллага, 3.1.3-3.1.5 дахь заалтад хамаарах байгууллагад хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэргийг тодорхой болгох талаар санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэх, хуульд заасан байгууллагуудын шилэн дансны мэдээллийг шилэн дансны зарчмыг баримтлан иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэхэд хяналт тавьж ажиллах, хуульд засан мэдээллийг байршуулаагүй төсвийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын зөрчлүүдийг арилгах зэрэг 3 зөвлөмжийг аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт аудитын албанд хүргүүлснээс 2 зөвлөмж бүрэн хэрэгжин, 1 зөвлөмж хэрэгжээгүйгээс өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт 72 байгууллагад 13 албан шаардлага, 62 зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

ДҮГНЭЛТ:

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах түүвэрт хамруулсан 78 байгууллагын шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаандаа мэдээллийг тогтмол мэдээлэх үүргийн хэрэгжилт 96.3 хувьтай гүйцэтгэжээ.
2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах түүвэрт хамруулсан 78 байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийн 3.4 хувийг мэдээлээгүй байна.
3. Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгаагүйгээс байгууллагууд шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбартаа дутуу байршуулж байна.
4. Шилэн дансны хуулийн 5.7 дахь заалтад нэмэлтээр мэдээллийн самбарт ил тод мэдээлэх талаар хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгах , эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.
5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, ажил үйлчилгээ гүйцэтгэж буй Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуй нэгж байгууллагуудын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдсан байдал хангалтгүй, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээлэл, төсвөөс авсан санхүүжилтийн дүнг цахим хуудсанд бүрэн байршуулаагүй байна.
6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аймаг сумдын ИТХ жилд 2 удаа, санхүүгийн хяналт, дотоод аудитын газар улирал бүр хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч хуулийн 6.9 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
7. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт 100 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга З.Батзоригтод:

1. Шилэн дансны хуулийн 3.1.1-д заасан байгууллагуудын хугацаандаа мэдээлээгүй мэдээллийг нөхөн байршуулах ажлыг зохион байгуулах, /судалгааны маягт, зөрчлийн нэгтгэл/, шилэн дансны тухай хуулийн 10.1- дэх заалтын дагуу хариуцлага тооцох.
2. Шилэн дансны тухай хуулийн 5.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх шат дараатай арга хэмжээг авах.
3. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5 дахь заалтад хамаарах байгууллагуудыг шилэн дансанд цахим хуудас нээгээгүй, мэдээллээ байршуулаагүй тохиолдолд санхүүжилтийн мэдээллийг бүрэн оруулахад чиглэсэн тусгай заалтыг гэрээнд зааж, хэрэгжилтийг хянах.

Мэдэгдэл:

Аудитад хамрагдсан санхүүгийн баримт, холбогдох тоо материалд тулгуурлан нотлох баримтыг хангаж, аудитын тайлан, дүгнэлтийг холбогдох

байгууллагын удирдлагад танилцуулж, ирүүлсэн саналыг аудитын тайланд тусгасан болно.

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гарсан үр дүнгийн талаар 2020 оны 12 дугаар сарын 01-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН
З.ГАНБААТАР